Удирдах зөвлөлийн 2021 оны
... сарын ...-ны өдрийн ... дугаар
тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ХАРЬЯА
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

# СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

**(2021-2024 он)**

**2021 он**

# НЭГ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Байгууллага нь өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд үйл ажиллагаандаа стратегийн удирдлага төлөвлөгөөг нэвтрүүлдэг бөгөөд стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хөгжлийн ирээдүйн чиг хандлага, алсын хараа, зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл тодорхой болж, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд үйл ажиллагаагаа нийцүүлэх боломж бүрдэнэ.

Стратеги төлөвлөгөөг боловсруулснаар сургууль нь удирдлага, зохион байгуулалтаа оновчтой төлөвлөж, техникийн болон мэргэжлийн боловсролын чанарыг төлөвшүүлэх, цахим сургалтын платформ, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, судалгаа, инновацийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх, санхүүгийн нөөцийг зохистой төвлөрүүлж, хуваарилах зэргээр байгууллагын хэвийн амжилттай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой. Түүнчлэн удирдлагуудад сургуулиа итгэлтэй, алсын хараатай удирдах, хамт олны үйл ажиллагааг нэг зүгт чиглүүлэн, төсвийг нэмэгдүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чухал нөлөөтэй билээ.

Иймд техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого, үзэл баримтлалд нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа магадлан итгэмжлэгдсэн Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж нь 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулсан болно.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль”, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулав.

Энэхүү стратеги төлөвлөгөө нь байгууллагын үйл ажиллагааны үр дүнг хангахад чиглэгдсэн бодлогын баримт бичиг тул түүний үнэт чанар нь төрийн албан хаагчдын өдөр тутмын ажилд шууд мэдрэгдэхээсээ илүү зөв бодлого, хандлага чиглэл, сэтгэлгээ, удирдлага, зохион байгуулалт, арга барил, ур чадвар, үр дүнг бий болгоход оршино.

Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн 2018-2021 оны стратеги төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжсэн бөгөөд Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2 дугаар хавсралт “Стратеги төлөвлөгөөний загвар”-ын дагуу байгууллагын 2021-2024 онд хэрэгжүүлэх байгууллагын мандат, алсын хараа, эрхэм зорилго, орчны шинжилгээ, стратегийн зорилго, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, арга замыг тодорхойлсон баримт бичгийг боловсрууллаа.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа сургуулийн багш, ажилтнууд, суралцагчид болон хамтран ажилладаг түншлэгч байгууллагууд, ажил олгогч нараас санал авч, баримт бичигт тусгаж ажилласан болно.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

*Мандатын шинжилгээний хүснэгт:*

| | | |
|---|---|---|
| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж нь үйл ажиллагаандаа 60 хуулийг мөрдлөг болгон, техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтыг олгон, мэргэжилтэй ажилтанг бэлтгэж байна. |
| Үүнээс | Тухайн салбарын хуулийн тоо: **16** | 1. Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль,<br>2. Боловсролын тухай,<br>3. Бага, дунд боловсролын тухай,<br>4. Дээд боловсролын тухай,<br>5. Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль,<br>6. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль,<br>7. Хүүхэд хамгааллын тухай хууль,<br>8. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль,<br>9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль<br>10. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль,<br>11. Эрүүл ахуйн тухай хууль,<br>12. Галын аюулгүй байдлын тухай хууль,<br>13. Эрүүл мэндийн тухай хууль,<br>14. Номын сангийн тухай хууль,<br>15. Статистикийн тухай хууль,<br>16. Биеийн тамир спортын тухай хууль,<br>17. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль,<br>18. Усны тухай хууль,<br>19. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тухай хууль,<br>20. Эрүүгийн тухай хууль,<br>21. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль,<br>22. Хөдөлмөрийн тухай,<br>23. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай,<br>24. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль,<br>25. Патентийн тухай хууль,<br>26. Тариалангийн тухай хууль |

| | | |
|---|---|---|
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо:**34** | 1. Төрийн албаны тухай хууль,<br>2. Монгол Улсын Үндсэн хууль,<br>3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,<br>4. Төсвийн тухай хууль,<br>5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,<br>6. Шилэн дансны тухай хууль,<br>7. Нийгмийн даатгалын тухай хууль,<br>8. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,<br>9. Тэтгэврийн тухай хууль,<br>10. Төрийн хяналт шалгалтын тухай хууль,<br>11. Аудитын тухай хууль,<br>12. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,<br>13. Татварын тухай хууль,<br>14. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,<br>15. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,<br>16. Авилгын эсрэг тухай хууль,<br>17. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонихрлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,<br>18. Усны тухай хууль,<br>19. Хувь хүний нууцийн тухай хууль,<br>20. Байгууллагын нууцын тухай хууль,<br>21. Мэдээллийн ит тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,<br>22. Газрын тухай хууль,<br>23. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль,<br>24. Иргэний хууль,<br>25. Зөрчлийн хууль,<br>26. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль,<br>27. Шуудангийн тухай хууль,<br>28. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль,<br>29. Монгол хэлний тухай хууль,<br>30. Гамшгийн тухай хууль,<br>31. Онц байдлын тухай хууль,<br>32. Тамхины хяналтын тухай хууль,<br>33. Цэргийн албаны тухай,<br>34. Хог хаягдлын тухай хууль, |

Ерөнхий чиг үүрэг-1: Сургуулийн хөгжлийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

| **Үндсэн чиг үүрэг** | **Дэд чиг үүрэг** | **Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид** |
|---|---|---|
| ҮЧҮ-1: Сургуулийн хөгжлийн бодлого төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг тасралтгүй хөгжүүлэх | Байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөртэй нийцүүлэн төлөвлөх | Менежер, дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ахлах ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах ажилтан, хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан, захирлын туслах, архив албан хэрэг хөтлөлтийн ажилтан |
| | Сургуулийг эрх ашгийг хамгаалах, нийгэм дэх нэр хүндийг өсгөх | |

| | | |
|---|---|---|
| | Цахим мэдээлэлд тулгуурласан төлөвлөлт, менежментийг хөгжүүлэн, цахим санг бүрдүүлэх | |
| ҮЧҮ-2 Чанарын баталгаажилтын тогтолцоог хөгжүүлэх, дотоодын эрх бүхий байгууллагаар хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэх | Сургуулийн дотоодын болон хөндлөнгийн байгууллагын чанарын баталгаажилтын тогтолцоог сайжруулах<br>Ажлын байрын соёлыг төлөвшүүлэх | Захиргаа, аж ахуйн менежер, сургалтын менежер, дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ахлах ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн, сургалтын арга зүйч нар, хүний нөөц гадаад харилцаа хариуцсан ажилтнууд, |
| **Ерөнхий чиг үүрэг-2: Мэргэжлийн боловсрол, сургалтын шаардлагад нийцсэн чанартай сургалт, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.** | | |
| ҮЧҮ-1: Сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах | Шаталсан хөтөлбөрийн залгамж холбоог хангасан сургалтын хөтөлбөрийг боловсруулан хөгжүүлэх<br>Сургалтын хөтөлбөрийн чанар, үр дүнг тасралтгүй сайжруулах | Сургалтын менежер, арга зүйч-багш, багш нар |
| ҮЧҮ-2: Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын элсэлт, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх | Зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаанд үндэслэн тэргүүлэх чиглэлээр шинэ мэргэжлүүдийг нээж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх<br>Сургуулийн элсэлт, төгсөлтийн бодлого, төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх<br>Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудыг зохион байгуулах<br>Төгсөгчдийн сургуультай эргэх холбоог нэмэгдүүлэх, насан туршдаа суралцахуйг дэмжиж, хамтран ажиллах | Сургалтын менежер, нийгмийн түншлэлийн арга зүйч нар, арга зүйч-багш, багш нар |
| **Ерөнхий чиг үүрэг-3: Суралцагчдад амьдрах ухааны ур чадвар бүхий хандлага, хөдөлмөрийн соёлыг төлөвшүүлэн, хувь хүний хөгжлийг дэмжинэ.** | | |
| ҮЧҮ-1: Нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ёс зүй, харилцаа хандлагатай, тасралтгүй хөгжигч, бүтээлч мэргэжилтэн бэлтгэх | Эцэг эх, асран хамгаалагчидтай хамтын ажиллагааг эрчимжүүлэн, суралцагчдын хүмүүжил | Сургалтын менежер, нийгмийн ажилтнууд, номын санч, эмч, дотуур байрын багш нар, багш нар |

| | | |
|---|---|---|
| | төлөвшил, сурах үйл ажиллагааг дэмжих | |
| | Насан туршийн суралцахуйг дэмжиж, хувь хүний хөгжлийг нэмэгдүүлж манлайлагч суралцагчдыг бэлтгэх | |
| ҮЧҮ-2: Хүүхдийн эрхийг дээдлэх, хүндэтгэх тэгш боломжоор хангах, суралцах эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх | Суралцагчдыг аливаа болзошгүй эрсдэлд нөхцөл, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх | Сургалтын менежер, нийгмийн ажилтнууд, номын санч, эмч, дотуур байрын багш нар, багш нар |
| | Дотуур байрны суралцагчдад ээлтэй хүртээмжтэй, аюулгүй, таатай орчин бүрдүүлэх | |
| **Ерөнхий чиг үүрэг-4: Нийгмийн түншлэлийн олон талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ.** | | |
| ҮЧҮ-1: Нийгмийн түншлэлийн дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, ажил олгогч, түншлэгч байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх | Нийгмийн түншлэлийн хамтын ажиллагааг цогц байдлаар хөгжүүлэх | Сургалтын менежер, нийгмийн түншлэлийн арга зүйч нар, арга зүйч-багш нар, багш нар |
| | “Багш-инженер-техникийн ажилтан” солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх | |
| ҮЧҮ-2: Нийгмийн түншлэлийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх | Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | Захиргаа, аж ахуйн менежер, хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтнууд |
| | Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн, сургуулийн орчин нөхцөлийг сайжруулах | |
| **Ерөнхий чиг үүрэг-5: Сургуулийн үйл ажиллагааны тогтвортой хөгжлийг хангахуйц нөөцийг төлөвлөж, бүрдүүлж, хөгжүүлнэ.** | | |
| ҮЧҮ-1: Хүний нөөцийн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах | Хүний нөөцийг оновчтой бүрдүүлж, тасралтгүй хөгжүүлэх | Захиргаа, аж ахуйн менежер, хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтнууд |
| | Нийгмийн баталгааг хангаж, чадавхыг бэхжүүлэх | |
| ҮЧҮ-2: Сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдах орчин нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн менежментийг төлөвшүүлэх | Сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдах сургалтын орчинг тогтмол сайжруулах | Захиргаа, аж ахуйн менежер, ерөнхий нягтлан бодогч, нягтлан бодогч, нярав |
| | Сургуулийн төсвийн төлөвлөгөөний төсөл боловсруулан хэлэлцүүлэн батлуулах, төсвийн орлого, зарлагыг үр ашигтай зарцуулан тайлагнах | |

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Олон улсын жишигт нийцсэн, үндэсний тэргүүлэгч сургалт, үйлдвэрлэлийн байгууллага болох

## ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, өрсөлдөх чадвартай, мэргэжлийн өндөр ёс зүй ур чадвар бүхий үндэсний мэргэжилтэй ажилтанг бэлтгэнэ.

## ҮНЭТ ЗҮЙЛ

- Тэнцвэртэй, тогтвортой, оролцоотой хөгжил
- Ардчилсан үзэл баримтлал
- Уламжлал ба шинэчлэл
- Хүний болон оюуны капитал, мэргэжлийн үнэлэмж
- Чанар, ил тод, хариуцлагатай байдал
- Шинэ бүтээл, бүтээлч сэтгэлгээ

## УРИА

- Чанартай орчин
- Чадварлаг багш
- Чадамжтай мэргэжилтэн
- Чинээлэг амьдрал

## ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

*Орчны шинжилгээний хүснэгт:*

<table>
<tr><th colspan="2">Дотоод орчны шинжилгээ</th></tr>
<tr><td>Давуу тал<br>- 1974 оноос аймаг, орон нутаг, улсын хэмжээнд техникийн болон, мэргэжлийн боловсролыг олгож байгаа туршлагатай сургууль<br>- Шаталсан сургалтын хөтөлбөртэй<br>- Байгууллагаа болон 2 хөтөлбөр магадлан итгэмжлүүлж, чанарын баталгаажилт хийлгэсэн.<br>- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайн.<br>- Ном сурах бичгийн хангамж сайтай.<br>- Багш боловсон хүчнээр бүрэн хангагдаж, мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь өндөр.<br>- Компьютер, интернетэд хамрагдаж цахим орчинд ажиллах боломж бүрдсэн.<br>- Анги танхим, номын сан, WiFi интернет сүлжээ, дадлагын газар, өвлийн хүлэмж зэрэг сургалтын ажил явуулах материаллаг орчны нөөцтэй.<br>- Сургалтын чанар үр дүнгээр хангайн бүсдээ тэргүүлэх байр суурь эзэлж, нэр хүнд нийгмийн эрэлт хэрэгцээ улам бүр өсөж байна.</td><td>Сул тал<br>- Сургуулийн барилга байгууламж дэд бүтэц, орчин үеийн дадлагын газар тоног төхөөрөмж, зарим хөрөнгө элэгдэж хуучирсан.<br>- Сургалтын материаллаг хэрэглэгдэхүүн, орчин үеийн лаборатори, багаж хэрэгслийн хүртээмж, чанар одоогийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй<br>- Гадаа талбайн ногоон байгууламжийн эзлэх хувь бага.<br>- Төсвийн хомсдолтой.<br>- Нийт багш нарын тоонд эзлэх магистр, доктор эрдмийн зэргийн эзлэх хувь хангалтгүй.<br>- Ажилтнуудын эрх зүйн мэдлэг хангалтгүй<br>- Багш нарын гадаад хэлний мэдлэг сул байгаагаас мэдээлэл олж авах явдал хязгаарлагдмал.<br>- Зарим нэг дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй<br>- Судалгаа хөгжүүлэлтийн бодлого сул.<br>- Төгсөгчдийн эргэх холбоо сул.<br>- Суралцагчдын ар гэрийн анхаарал муу.</td></tr>
<tr><th colspan="2">Гадаад орчин</th></tr>
<tr><td>Боломж<br>- Улсын хөгжлийн төлөвлөгөө болон аймаг, орон нутгийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтыг тэргүүлэх чиглэлээр хөгжүүлж, мэргэжилтэй ажилтанг бэлтгэхэд онцгойлон анхаарсан.<br>- Өвөрхангай аймаг “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого”-оор 116732 хүн амтай, улсын хэмжээнд 3 дугаарт ордог, нийт хүн амын 64,5 хувь нь ажиллах хүчин байна.<br>- Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн шинэчлэл хийгдэж, сургуулийн бие даасан байдлыг хангах, багшийн хөгжлийг дэмжих, чанарын баталгаажилтын тогтолцоо, мэргэшлийн түвшний хүрээг бүрдүүлэхэд чиглэж байгаа нь хөгжих боломжийг хангаж байна.<br>- Эцэг эхчүүд хүүхдээ мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагыг сонгон суралцуулах, хангалттай мэдлэг чадвар эзэмшүүлэх сонирхол, хэрэгцээ өсөн нэмэгдэж байна.<br>- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг хөгжүүлэх эрх зүйн орчин шинэчлэгдэн, төрөөс бодлогоор дэмжиж байгаа нь нийгэмд үнэлэгдэх үнэлэмж нэмэгдэж байна.<br>- Дотоод, гадаадын ижил төстэй сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой.</td><td>Эрсдэл<br>- Техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад сурлага муутай хүүхэд сурдаг гэсэн нийгэмд сөрөг хандлага одоо ч байгаа тул хандлагыг өөрчилж, үнэ цэнэ үнэлэмжийг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна.<br>- Суралцагчид Улаанбаатар хотруу сурах сонирхол ихтэй байдаг тул өрсөлдөөн нэмэгдэж байна.<br>- Суралцагчдын ар гэрийн амжиргааны түвшин доогуур байдаг.<br>- Мэдээллийн хяналтгүй байдал суралцагчдад эсрэгээр нөлөөлдөг.<br>- Сургалтын агуулга, хөтөлбөр ойр ойрхон өөрчлөгддөг.<br>- Төрөөс сургалтын орчин, дадлагын тоног төхөөрөмжийг сайжруулахад анхаардаггүй.</td></tr>
</table>

## ГАДААД ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Монгол улсын болон аймаг орон нутгийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтөд техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтыг тэргүүлэх чиглэлээр хөгжүүлэхээр төлөвлөн, Монгол улсын бүтээн байгуулалтад ажиллах ур чадвартай мэргэжилтэй ажилтанг бэлтгэхэд анхаарч, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийг шинэчлэн мэргэжлийн үндэсний хүрээ, чанарын баталгаажилтын тогтолцоо бүрдүүлэхэд чиглэж, мэргэжлийн боловсрол сургалтын үнэ цэнийг нэмэгдүүлж, суралцагчдад тэтгэлэг олгож байгаа нь чадамжтай мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлж байна.

Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж нь техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтыг олгох шаталсан сургалтыг хөгжүүлж, дотоодын эрх зүйн орчинг бүрэн төлөвшүүлж, 1974 оноос сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн, боловсон хүчний тасралтгүй залгамж халаа, хүний нөөц хүрэлцээ сайтай, ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын сургуулиудтай хамтын ажиллагаагаа эрчимтэй хөгжүүлж байгаагаас гадна Өвөрхангай аймгийн хүн ам улсын хэмжээнд 3 дугаарт орж байгаа нь техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын эрэлтийг нэмэгдүүлэх чухал үзүүлэлт юм.

Бид гадаад дотоод орчны шинжилгээнээс үндэслэн сургалтын чанар хүртээмж, шаталсан сургалтын хөтөлбөрийг нэмэгдүүлэх, суралцагчдын мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд анхаарах, хүний нөөцийн инновацийн бүтээлч хөгжлийг тасралтгүй дэмжих, мэргэжлийн боловсрол, сургалтын үнэ цэнэ, үнэлэмжийг нэмэгдүүлэх, гадаад дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх, материаллаг нөөц баазыг сайжруулан, чанарын соёлыг төлөвшүүлэх, өөрийн брэнд онцлог, хэрэглэгчдэд хүрсэн үйлчилгээ үзүүлэх зэрэгт онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байна. Иймд орчны шинжилгээнд үндэслэн сургуулийн энэхүү стратеги төлөвлөгөөг 4 жилийн хугацаатайгаар боловсруулсан болно.

## ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Сургуулиа бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх сургууль болгон хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан мэргэжилтэй ажилтанг бэлтгэх, төгсөгчдийг ажлын байраар хангах, нийгмийн түншлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, хөдөлмөрийн болон чанарын соёлыг төлөвшүүлэн ажиллахад энэхүү хөгжлийн бодлого хөтөлбөрийн зорилго оршино.

## ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

**Дээд шатны байгууллага:**

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Мэргэжлийн боловсрол сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

**Мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилладаг байгууллага:**

- Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ мэдээллийн арга зүйн төв
- Хангайн бүсийн арга зүйн алба
- Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн Удирдах зөвлөл
- Мэргэжлийн боловсрол сургалтын Орон нутгийн салбар зөвлөлийн Өвөрхангай аймгийн салбар зөвлөл

**Орон нутагт хамтран ажилладаг байгууллага:**

- Аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар
- Өвөрхангай аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс
- Өвөрхангай аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
- Сумдын Засаг дарга, Засаг даргын тамгын газар
- Түншлэн ажилладаг бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж

## НАЙМ. ХАВСРАЛТ ХОЛБОГДОХ МАТЕРИАЛ

- Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн өмчийн тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт
- Монгол улсын урт хугацааны бодлого “Алсын хараа-2030”
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2025)
- Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл
- Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Засгийн газрын 2020 оны 2016 дугаар тогтоол “Стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”
- Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоол “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал” 2 дугаар хавсралт “Стратеги төлөвлөгөөний загвар”
- Хүн амын орон сууцны 2020 оны Өвөрхангай аймгийн ээлжит тооллогын нэгдсэн дүн
- Өвөрхангай аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа-2018
- www.legalinfo.mn
- www.cabinet.gov.mn
- www.mlsp.gov.mn
- www.uvurkhangai.gov.mn
- www.1212.mn
- www.uv-college.mn

# ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН 2021 ОНЫ ТӨСӨВ

| | Нийт батлагдсан төсөв |
|---|---|
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,313,826.5 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 3,313,826.5 |
| БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,076,045.9 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,836,467.7 |
| Үндсэн цалин | 1,174,990.3 |
| Нэмэгдэл | 499,794.3 |
| Унаа хоолны Хөнгөлөлт | 78,408.0 |
| Урамшуулал | 83,275.1 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 247,923.1 |
| Тэтгэврийн даатгал | 174,464.4 |
| Тэтгэмжийн даатгал | 18,364.7 |
| ҮОМШ-ний даатгал | 14,691.7 |
| Ажилгүйдлийн даатгал | 3,672.9 |
| Эрүүл мэндийн даатгал | 36,729.4 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 715,545.3 |
| Гэрэл, цахилгаан | 72,424.2 |
| Түлш, халаалт | 585,812.2 |
| Цэвэр, бохир ус | 57,308.9 |
| Хангамж, бараа материалын зардал | 17,804.2 |
| Бичиг хэрэг | 2,182.9 |
| Тээвэр, шатахуун | 5,229.8 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,368.3 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,061.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,962.2 |
| Нормативт зардал | 142,811.9 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 347.8 |
| Хоол, хүнс | 120,150.0 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 22,314.1 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 88.0 |
| Урсгал засвар | 88.0 |

| | |
|---|---|
| Томилолт, зочны зардал | 1,292.3 |
| Дотоод албан томилолт | 1,292.3 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,312.6 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500.0 |
| Даатгалын үйлчилгээ | 4,000.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 1,880.0 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 3,000.0 |
| Мэдээллийн технологийн үйлчилгээ | 2,970.0 |
| Газрын төлбөр | 1,478.5 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 484.1 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 97,800.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 2,814.9 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 94,985.9 |
| Урсгалшилжүүлэг | 237,780.6 |
| Бусад урсгал шилжүүлэг | 237,780.6 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 115,312.9 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 119,761.7 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,706.0 |
| Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 3,313,826.5 |
| Улсын төсвөөс санхүүжих | 3,248,826.5 |
| Улсын төсвөөс санхүүжих | 3,248,826.5 |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 65,000.0 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 65,000.0 |
| Төсвийн бусад мэдээллийн ангилал | 269.0 |
| Байгууллагын тоо | 1.0 |
| Төсвийн байгууллага | 1.0 |
| Ажиллагсдын тоо | 132.0 |
| Удирдах ажилтан | 4.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 97.0 |
| Үйлчлэх ажилтан | 31.0 |
| Орон тооны мэдээлэл | 132.0 |
| Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 79.0 |

| | |
|---|---|
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 53.0 |
| НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ | 4.0 |
| Боловсролын тухай хуулиар тэтгэвэрт гарагч | 4.0 |

--o0o--

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
2 дугаар хавсралт

# ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН

# СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2021-2024 ОН)

*Төлөвлөгөөг баталсан:* *Төсвийн Шууд захирагч*

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ .............................. САРАЙСАНДАМБЫН САНЧИР

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг* .........................

*(огноо)*

*Төлөвлөгөө боловсруулсан:* *Төрийн албан хаагч*

СУРГУУЛИЙН ДЭД ЗАХИРАЛ ............................ ЦЭНД-АЮУШИЙН БАТЖАРГАЛ

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг* .........................

*(огноо)*

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ХАРЬЯА МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

| Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Санхүүгийн эх үүсвэр (мянган төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| *Ерөнхий чиг үүргийн нэр:* ***Сургуулийн хөгжлийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.*** | | | | | |
| *Үндсэн чиг үүргийн нэр: Сургуулийн хөгжлийн бодлого төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг тасралтгүй хөгжүүлэх* | | | | | |
| **Зорилт-1** Байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөртэй нийцүүлэн төлөвлөх | Улсын болон аймаг орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан сургуулийн бодлого, хөтөлбөр дүрэм, журмыг шинэчлэх | 2021 онд 4-өөс доошгүй бодлого, хөтөлбөр, дүрэм журмыг шинэчлэн хэрэгжүүлэх<br>2022 онд 5-аас доошгүй бодлого, хөтөлбөр дүрэм, журмыг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллах<br>2023 онд 5-аас доошгүй бодлого, хөтөлбөр, журмыг шинэчлэн, хэрэгжүүлж ажиллах<br>2024 онд 6-аас доошгүй бодлого, хөтөлбөр дүрэм, журмыг боловсруулан, үйл ажиллагаандаа мөрдөг болгох | 2020 онд 2 дэд хөтөлбөр, 8 дүрэм, журмыг шинэчлэн, хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 онд дүрэм журмын эмхтгэлийг гаргасан. | Улсын болон аймаг, орон нутгийн бодлого хөтөлбөртэй нийцүүлэн, сургуулийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг шинэчлэн сайжруулж, хэрэгжилтийг ханган ажиллана. | 1500,0 мянган төгрөг |
| | Сургуулийн эрх ашгийг хамгаалах, нийгэм дэх нэр хүндийг өсгөх | 2021 онд Сургуулийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах<br>2022 онд сургуулийн нийгэм дэх нэр хүндийг өсгөх 10-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулах<br>2023 онд сургуулийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, эрх ашгийг хамгаалах дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг хангах<br>2024 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн хангаж, мэргэжлийн боловсролын үнэ цэнэ, үнэлэмжийг нэмэгдүүлэх 10-аас доошгүй ажил үйлчилгээг зохион байгуулах | Сургуулийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | Сургуулийн эрх ашгийг хамгаалж, нийгэм дэх эерэг төсөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн, техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын үнэ цэнэ үнэлэмжийг нэмэгдүүлж ажилласан байна. | 8500,0 мянган төгрөг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | Цахим мэдээлэлд тулгуурласан төлөвлөлт, менежментийг хөгжүүлэн, цахим санг бүрдүүлэх | 2021 онд сургуулийн сүүлийн 10 жилийн захирамжлалын баримт бичгийг цахимжуулах<br>2022 онд бүх захирамжлалын баримт бичгийг цахим санд бүртгэх<br>2023 онд явсан бичгийг цахимжуулах<br>2024 онд ирсэн бичгийг цахимжуулж, цахим санг бүрэн бий болгох | 1986-2010 оны захирамжлалын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж ажилласан. | Сургуулийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, цахим мэдээллийн сантай болсон байна. | 1200,0 мянган төгрөг |
| *Үндсэн чиг үүрэг:* Чанарын баталгаажилтын тогтолцоог хөгжүүлэх, дотоодын эрх бүхий байгууллагаар хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэх | | | | | |
| **Зорилт-1.** Сургуулийн дотоодын болон хөндлөнгийн байгууллагын чанарын баталгаажилтын тогтолцоог сайжруулах | Сургуулийн дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шалгалт хийх | Сургалтын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах дотоод хяналт шалгалтыг зохион байгуулан чанарын баталгаажилтыг төлөвшүүлэх<br>- 2021 онд 23 удаа<br>- 2022 онд 25 удаа<br>- 2023 онд 28 удаа<br>- 2024 онд 28 удаа | 2020 онд 28 удаагийн дотоод хяналт шинжилгээ үнэлгээг зохион байгуулан, ажил үйлчилгээг сайжруулсан. | Сургуулийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн, аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлэн, дотоод чанарын баталгаажилтыг төлөвшүүлнэ. | 3000,0 мянган төгрөг |
| | Хөндлөнгийн байгууллагаар чанарын баталгаажилт хийлгэх | 2021 онд 2 хөтөлбөрт хөндлөнгийн чанарын баталгаажилт хийлгэх<br>2022 онд 2 хөтөлбөрт хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэх хамтын ажиллагааг эхлүүлэх<br>2023 онд 2 хөтөлбөрийн хөндлөнгийн баталгаажуулалтыг хийлгэх<br>2024 онд байгууллагын хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын хугацааг сунгах | БМИУЗ-ийн Удирдах зөвлөлийн тогтоол ор 5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэгдсэн. | Хөндлөнгийн байгууллагаар чанарын баталгаажилт хийлгэж, чанарын соёлыг төлөвшүүлнэ. | 40,000,0 мянган төгрөг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт-2.** Ажлын байрын соёлыг төлөвшүүлэх | Сургуулийн багш ажилтнууд, суралцагчдын аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, аюулгүй сургалтын орчин, ажлын байрыг бий болгох | 2021 онд ажлын байрын 5-с соёлыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах<br>2022 онд хөдөлмөрийн аюулгүй байдлын зөв зан үйлийг байгууллагын хэмжээнд төлөвшүүлэх 10 удаагийн арга хэмжээг зохион байгуулах<br>2023 онд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хяналтын тогтолцоог бий болгож хэвшүүлэх<br>2024 онд аюулгүй, эрүүл орчинд ажиллах нөхцөлөөр хангах 10 ажлыг зохион байгуулах | 2020 онд багш суралцагчдыг хамруулсан 10 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. | Сургуулийн багш, ажилтан, суралцагчдын аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан орчинг бүрдүүлж, ажлын байрын соёлыг нэвтрүүлсэн байна. | 9,500,0 мянган төгрөг |
| *Ерөнхий чиг үүргийн нэр:* ***Мэргэжлийн боловсрол, сургалтын шаардлагад нийцсэн чанартай сургалт, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.*** | | | | | |
| *Үндсэн чиг үүргийн нэр:* Сургалтын чанар хүртээмжийг сайжруулах | | | | | |
| **Зорилт-1.** Шаталсан, залгамж холбоог хангасан сургалтын хөтөлбөрийг боловсруулан хөгжүүлэх (богино, түр хугацааны мэргэжлийн сургалт, мэргэжлийн боловсролын сургалт, техникийн боловсролын сургалт) | Техникийн болон мэргэжлийн боловсролын шаталсан, залгамж холбоог хангасан сургалтын хөтөлбөрийг боловсруулан хөгжүүлэх | 2021 онд техникийн боловсролын 3 дүрэм, журмыг шинэчлэн боловсруулах<br>2022 онд Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын 3 хөтөлбөрт сайжруулалт хийх<br>2023 онд Техник, мэргэжлийн боловсролын сургалтын 5 хөтөлбөрт сайжруулалт хийх<br>2024 онд Богино хугацааны сургалтын хөтөлбөр боловсруулан хөгжүүлэх | -Мэргэжлийн боловсролын 5 дүрэм, журмыг шинэчлэн боловсруулсан.<br>-Техникийн боловсролын сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулсан.<br>-Богино хугацааны 10 мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулсан. | Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалт явуулах эрх бүхий 5-аас дээш мэргэжлийн хөтөлбөрийг сайжруулан боловсруулсан байна. | 12,500,0 мянган төгрөг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Цахим, зайн сургалтын дэвшилтэт арга зүйг сургалтад нэвтрүүлэх, хөгжүүлэх | 2021 онд цахим зайн сургалтын дүрэм, журмыг боловсруулах<br>2022 онд сургалтын хөтөлбөрийн 30 хувиас доошгүйг цахим хэлбэрт шилжүүлэх<br>2023 онд цахим, зайн сургалтын платформыг хөгжүүлэх<br>2024 онд цахим сургалтын орчинг бий болгох | Сургалтын хөтөлбөрийн 10-аас дээш хувь нь цахим хэлбэрт шилжсэн бөгөөд зайн сургалтын платформыг хөгжүүлэн цахим хичээлүүдийг байршуулан ажиллаж байна. | Цахим сургалтын орчинг шинээр бий болгож, зайн болон цахим сургалтын платформыг хөгжүүлэн хичээлийн 30-50 хувийг байршуулна. | 4600,0 мянган төгрөг |
